



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.9, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагуудын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ


080643

Эрүүл мэндийн сайдын
2016 оны 12 сарын 26-ны өдрийн
А/168 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Нандин трейд ХХК	эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Ига ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх	3 жил
3	Лондон луук ХХК	эм ханган нийлүүлэх	3 жил
4	НТХ ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх, нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх	3 жил
5	Нуган трейд ХХК	нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх	3 жил
6	Жейлвита ХХК	дотрын өвчний эмчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
7	Санни смайл ХХК	уруул тагнайн төрөлхийн сэтэрхий эмгэгтэй хүүхдийн шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
8	Сондра ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх	3 жил
9	Сондра ХХК	нүдний оношлогоо эмчилгээ, нүдний мэс заслын эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
10	Глорио диос ХХК	шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил

Эрүүл мэндийн сайдын
2016 оны 12 сарын 06-ны өдрийн
А/168 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Етомо ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Тун фарм ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх	3 жил
3	Архон ХХК	вакцин импортлох, ханган нийлүүлэх	3 жил